



ДОРНОД АХЛАХ СУРГУУЛЬ

2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛТЫН ТАЙЛАН



МУИС-ИЙН ХАРЬЯА ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН АХЛАХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ш.МАНДАХ


2024.06.19


ДОРНОД ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА **ДОРНОД АХЛАХ СУРГУУЛЬ НЬ** Монгол улсын Засгийн Газрын 2023 оны 08 сарын 23-ны өдрийн “Төрийн өмчийн зарим их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 307 ТОГТООЛООР НЭРШИЛ ӨӨРЧЛӨГДСӨН.

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА ДОРНОД АЙМАГ ДАХЬ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН АХЛАХ СУРГУУЛЬ




ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ



ЗОРИЛТ 1.  Суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцлийн бүрдүүлэх, сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах **Цахим систем хөгжүүлэлт, сургалтын тасралтгүй бэлэн байдал**

Ахлах ангийн суралцагчийн зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцлийг бүрдүүлж, багш нарын ажлын ачааллыг багасгах, сургалтын хэрэглэгдэхүүн, цахим системийн ашиглалтыг дэмжих үүднээс 4 ангийг “Maxhub 65” ухаалаг дэлгэцээр хангав. Багш нар өөрийн хичээлийн онцлогтой уялдуулан InDesign CC, Corel DRAW, Zip Grade, Adobe Illustrator 4-6 төрлийн программ аппликейшн, платформ, онлайн хичээлийг ашиглаж байна.


Англи, Хятад, Солонгос хэлний сургалтад багшийн, сурагчийн, дасгал ажлын зэрэг сурах бичгээр хангаж байна. Англи хэлний FOCUS ON 3, FOCUS ON 4, INTERPRISE B1, INTERPRISE B1+ сурах бичгээр 75-100%, солонгос хэлний болон хятад хэлний сурах бичгээр сурагчдыг бүрэн хангасан.



МУИС-ийн төв ахлах сургуулийн Oxford хөтөлбөр хэрэгжүүлдэг туршлагыг нэвтрүүлэх боломжийг судалж Pearson хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 10, 11 дүгээр анги тус бүрд 15 сурах бичиг, платформыг эхний ээлжинд авч, сурагчдад хаяг бүртгэл үүсгээд байна.

ЗОРИЛТ 2. Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, тэгш хамруулан сургах, тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах **Хүүхдийн ялгаатай хэрэгцээ, тэгш хамран сургалт, сурлагын хоцрогдол арилгах**

Тэгш хүртээмжтэй, тэгш боломж олгох зорилгоор Дорнод аймгийн 14 сум, Сүхбаатар, Төв аймгаас суралцагчид элсэн суралцаж байгаа ба математик, гадаад хэлний гүнзгийрүүлсэн ангид харьяалал харгалзахгүй сургаж байна. (авьяас, хэл, соёл, байршлын ялгаа)




Суралцагчдын 67% сурах арга барил муу, шинээр элсэгчид сурлагын хоцрогдол ихтэй тул суралцагч бүрийг оношлох, явц, ахицын үнэлгээнд анализ хийж ажиллахад хичээлүүдийн **оношлох шалгалтын дундаж гүйцэтгэл 48.5%** 2 дугаар улирлын **явцын шалгалтын гүйцэтгэл 70.1%** болж **21 хувиар**, 3 улирлын явцын гүйцэтгэл 70.8% -тай үнэлэгдсэн. Математик, монгол хэл, үндэсний бичиг, уранзохиол, англи хэлний хичээлийн явцын үнэлгээний ахиц **7.9-14.9%** ахисан бол бусад хичээлийн ахиц **21-28.7%**-иар ахисан.

УРИА Хүүхдийн хөгжлийн төлөө бид хамтдаа

Суралцагчийн **суурь мэдлэг чадварыг ахиулж**, сурах арга барилд сургаж, багш, суралцагчийн **хөгжлийг дэмжин**, сургалт үйл ажиллагааны **чанарт ахиц гаргана.**

2023-2024 Сургуулийн зорилго



ЗОРИЛТ 3. Байгууллагын менежментийн төлөвлөлт, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох **Байгууллагын менежментийн төлөвлөлт, багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа**



ЗОРИЛТ 3. Байгууллагын менежментийн төлөвлөлт, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох **Байгууллагын менежментийн төлөвлөлт, багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа**

Багш солилцоо (туршлагаа хуваалцах)

МУИС-ийн харьяа Байгаль-Эх лицей сургуулийн математикийн сонгоны хичээлээс туршлага судлахаар математикийн багш Б.Болортуяа, химийн, биологийн хичээлд туршлага судлуулахаар 106 Нарансолонго, 12а Б.Дөлгөөнбилэг нарыг сурагч солилцоо хөтөлбөрт 7 хоногийн хугацаатай хамруулж, МИУС-ийн доктор профессор 4-5 багшийн хичээлд сууж, сургалтын үйл явц болон онол, арга зүйн мэдлэгээ сайжруулж, багш сурагчдын мэдлэг чадвар, хичээлийн идэвх оролцоо арга туршлагаас суралцаж ирсэн.

Түүх нийгмийн багш Б.Ундармаа УБ хотын 33-р сургуульд 1 өдөр ажиллан хичээл зааж, улсын уралдааны оролцогч багшаас туршлага судалсан.



“Чадварлаг залуу багш” ур авьяасын уралдаан Хөлөнбуйр суманд болоход

- Сэтгэлгээний ур авьяас буюу эсээ бичлэгийн уралдаанд монгол хэлний багш Б.Мөнхтуяа 1-р байр, математикийн багш Б.Болортуяа 4-р байр
- Мэргэжлийн ур авьяас буюу ээлжит хичээлийн уралдаанд математикийн багш Б.Болортуяа 3-р байр, англи хэлний багш П.Будсүрэн 5-р байр
- Бүтээмжийн ур авьяас буюу цахим хичээлийн уралдаанд англи хэлний багш П.Будсүрэн 3-р байр эзлэв.



Бүсийн ЭШХ-д англи хэлний багш Б.Баярцэцэг, П.Будсүрэн нарын хамтарсан “Багш, суралцагчдын хамтын оролцоонд суурилан “Extensive reading” аргачлалаар англи хэлний чадварыг дээшлүүлэх нь” сэдэвт илтгэл Тэргүүн байрт, аймгийн СНА дунд явагдсан илтгэлийн уралдаанд нийгмийн ажилтан Д.Балжиндуламын “Багийн ажил-бидний амжилт хөтөлбөрийн үйл ажиллагаагаар анги бүлгийг хөгжүүлэх нь” илтгэл 3-р байрт шалгарсан.



ЗОРИЛТ 4. “Тэргүүлэх болон Зөвлөх багшийн манлайлал”-ыг дээшлүүлэх арга хэмжээ, ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш, ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх
Ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш, ажилтны солилцоо

Ахлах сургуулийн “Тэргүүлэх зэрэгтэй багшийн манлайлал” үйл ажиллагаанд физикийн багш Б.Мөнхтуяа “Долгины шинж, чанар” үзүүлэх хичээлийг, түүх, нийгмийн багш Б.Ундармаа “Олимпиадад хэрхэн тууштай бэлтгэх арга зүй”, “Даалгаварт шинжилгээ, чанарын анализ хийж, үр дүнгээ тооцох тухай” өөрийн туршилагыг, математикийн багш Б.Ганбаяр “Удирдсан ангитай хэрхэн ажиллах арга зүй” туршилага түгээн дэлгэрүүлэлт ажлыг зохион байгуулав.

“Богцтой хөтөлбөр 4-р бүсийн сургуульд хэрэгжиж Сэргэлэн сумын сургуульд физикийн багш 12 цагийн хичээл сургалт явуулж, мэргэжлийн багш Сарангэрэлтэй хамтран туршилтат хичээл, физикийн бодлого аргачлалын талаар туршлага солилцсон.

“ЭЕШ-2024” ажлын хүрээнд Чулуунхороот суманд Физикийн хичээлийн вакумжуулсан сургалтыг 10-12 ангийн 14 сурагчдад 80 цагийн сургалт, зөвлөх үйлчилгээг зохион байгуулсан.

Арлын ЯПОН УЛСАД туршлага судлахаар 8 сургуулийн 18 багш удирдлагыг оролцуулсан 7 шөнө 8 өдрийн аялалд Ахлах сургуулийн сургалтын менежер оролцож, Чиба аймгийн тусгай сургалттай Нагарэяма сургуулийн үйл ажиллагаа, гар доорх материал ашиглаж сурагчдыг хэрхэн амьдрах ухаанд сургадаг арга туршлагаас суралцсан.



АНУ-ын Бригамм Янгийн Их Сургуулийн Боловсрол соёлын өдрүүдээр англи хэлний багш нарын Олон улсын Заах арга зүйн зөвлөгөөн УБхотод зохион байгуулагдахад багш П.Будсүрэн оролцож туршлага судлав.



ЗОРИЛТ 5.



Багш, ажилтан албан хаагчдад стрессээс сэргийлэх, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах
Ажлын байрны эерэг уур амьсгал, байгууллагын соёл

УНШИГЧ ХАМТ ОЛОН- XREADING ЦАХИМ НОМ


- ✓ Улсын уншлагын ганцаарчилсан марафонд – 3 багш улсад 1-3 байрт
- ✓ Улсын "Багийн марафон"-нд Багш нарын баг улсад 4 дүгээр байрт шалгарсан.

НОД АЙМАГ ДАХЬ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН АХЛАХ СУРГУУЛИЙН БАГШ НАРЫН "XREADING" ЦАХИМ НОМ УНШЛАГЫН ЖИЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Books Added	Books Passed	Words Read	Avg Book Level	Read Time(h:m:s)	Read Speed(W ord/Min)	Listen Time(h:m:s)	Quizzes Taken	Quizzes Passed	Quiz Avg
48	43	412,007	8	52:41:23	130.3	18:53:10	47	44	81.7
136	130	308,996	8	107:49:49	47.8	28:03:05	132	130	87.6
129	99	158,130	3	27:47:34	94.8	21:28:20	122	99	75.1
88	83	150,240	3	74:45:32	33.5	25:38:40	86	84	93.7
163	161	97,141	4	33:25:49	48.4	5:58:40	163	161	82.8
111	76	46,527	3	11:59:26	64.7	4:25:50	107	76	64.1
21	15	6,980	1	3:18:20	35.2	0:47:50	16	15	83.8
51	11	2,370	2	0:40:35	58.4	0:01:00	36	12	41.7
41	9	1,592	1	0:55:07	28.9	0:05:00	34	10	38.2
18	10	927	1	1:27:35	10.6	0:00:30	14	10	62.9



"ИЖИЙ БУРХАД МИНЬ" үйл ажиллагаа Ээж нартаа хүндэтгэл үзүүлж өөрсдийн дурсамж, дурдатгал, сэтгэлийн үгээр ном бэлтгэн гаргаж, Сүхбаатар аймаг, Улаанбаатар хот, Дорнод аймгийн сумдаас хүрэлцэн ирсэн ээжүүдээ Чойбалсан хотын хөшөө дурсгалаар аялуулж, аймгийн театрийн "Ижий цэцэг минь" тоглолтыг хамтран үзэж, нэг өдрийг сэтгэл дүүрэн хамтдаа тэмдэглэв.




ХАМТ ОЛНЫ АЯЛАЛ-ыг 4 жилдээ зохион байгуулж байна. Эх орныхоо үзэсгэлэнт газруудаар аялаж, хамтач байдлыг бэхжүүлэх, бие биенээсээ суралцах ЗҮҮН ХЯЗГААРААС БАРУУН ХЯЗГААРТ АЯЛАЛ 15 аймгийн сумаар дайран өнгөрч, ӨВӨРХАНГАЙ, БАЯНХОНГОР, ГОВЬ-АЛТАЙ, ХОВД, БАЯН -ӨЛГИЙ, УВС, ХӨВСГӨЛ, БУЛГАН, ОРХОН, ДАРХАН-УУЛ гэсэн 10 аймгийн төвийг үзэж танин мэдэхүйгээ нэмэгдүүлсэн.



ЗОРИЛТ 6 Сургуулийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, сурах, хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх, үр дүнг тооцох **Хүүхэд хамгааллын үйлчилгээ, сурч, хөгжих төлөвших явцыг дэмжих**

- ✓ Сургуулийн хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааны төлөвлөлтөд 14 ажил төлөвлөн, 92 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.
- ✓ БЕГ-аас зохион байгуулсан хүүхдийн хөгжлийн **“After school” платформ сургалтыг** 7 хоног бүрийн 4 дэх өдрийн 15:00-17:30 хооронд явуулж, 10-12 дугаар ангийн 69 сурагч тус платформд бүртгэл үүсгэж, 10-11 дүгээр ангийн нийт 41 сурагчид хөгжлийн сургалтад хамрагдах хичээл зохицуулалтыг хийж, **27 төрлийн хөгжлийн сургалтад 90 хувийн гүйцэтгэлтэй хамруулж хөгжүүлж ажиллав.**
- ✓ Фокус бүлгийн ярилцлагаар сургуулийн төлөөлөл 10-12 ангийн 41 суралцагчдын санал асуулгаар **сургуулийн орчинд дээрэлхэлт байхгүй** гэж харуулсан.

Зохион байгуулсан ажлын тоо	Хамрагдсан суралцагч
Гэмт хэргээс сэргийлэх сургалт-6	67
Хорт зуршлаас сэргийлэх сургалт- 4	69
Хөгжлийн сургалтууд - 8	69
Ажил мэргэжлийн чиг баримжаа- 7	60
Зохион явагдсан аянууд- 5	69
Өдөрлөг, хэлэлцүүлэг- 2 НИЙТ -32 АЖИЛ	69 - 404 хүүхэд, 59 эцэг эх




Баяндун суманд явагдсан **“Оролцоод хөгжье” ангийн дарга нарын анхдугаар чуулганд** ахлах сургуулийн 12 багш, сурагч оролцон анги удирдах туршлагаа түгээн дэлгэрүүлэв.



- ✓ Ажлын тайланг сургуулийн эцэг эхийн тайлант өдөрлөгөөр **“Хуулиа хэрэгжүүлье, хүүхдээ дэмжье, хамгаалья”** уриатай зохион явуулж, нийт эцэг эхийн 78%-ийг хамруулав.

ЗОРИЛТ 7. Байгууллагын орчны эрсдлийг бууруулах, дотоод хяналтыг тогтмолжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцох **Байгууллагын орчны эрсдэл, дотоод хяналт**



МАТЕРИАЛЛАГ ОРЧИН

- Сургууль, ангийн өнгө, тохижилт
- Гэрэлтүүлэг, агааржуулалт
- Тоног төхөөрөмж

СЭТГЭЛ ЗҮЙН ОРЧИН

- Ялгаварлан гадуурхалтгүй орчин
- Багшийн зан үйл, эерэг байдал мотиваци
- Хүндлэл дэмжлэг бүхий найрсаг, стрессгүй

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЧИН

- Хооллолт, эрүүл мэндийн үйлчилгээ
- Бүлэг дүүргэлт
- Сурагч бүрийг дэмжсэн үйлчилгээ

Сургуулийн орчны үнэлгээг MNS67822019 стандартын 4 агуулгын 224 асуултын дагуу 2 удаа хийв.

Хөөсний баяр- эвдрэл засах, анги танхим, сургуулиараа их цэвэрлэгээ хийх

Охидын ариун цэврийн өрөө нь ганц суултууртай учир завсарлагааны цагт хэт их дугаарлан, хичээл хоцрох асуудалтай, бохирын үнэр байнга үнэртдэгээс орчны ариун цэвэрт сөрөг нөлөөтэй байсан тул 5 суултууртай болгож, засч тохижуулав.



ЗОРИЛТ 8. арга хэмжээ

Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагаа,



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ХАРЬА ДОРНОД АЙМАГ ДАХЬ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН АХЛАХ СУРГУУЛЬ



СУРГУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Дорнод их сургуулийн Удирдах зөвлөлийн 2015 оны 05 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/205 дугаар тушаалаар Дорнод их сургуулийн харьяа Математик-Гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын Дорнод ахлах сургууль байгуулагдсан. Анх 10 дугаар ангид 15 сурагчидтайгаар сургалтаа эхлүүлж байсан бол эдүгээ 9 дэх хичээлийн жилдээ 10-12 дугаар ангийн 70 хүүхдэд математик, физик, англи, хятад, солонгос хэлээр гүнзгийрүүлсэн сургалтыг амжилттай зохион байгуулж байна.

Монгол улсын засгийн газрын 2023 оны 307 дугаар тогтоолоор **“МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ХАРЬА ДОРНОД АЙМАГ ДАХЬ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН АХЛАХ СУРГУУЛЬ”** болж өргөжин тэлж байна.

СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖИЛ

- Үндэсний түүх соёлоо дээдэлдэг эх оронч үзэлтэй хүмүүн төлөвшүүлэн, эх орны түүхээс суралцах **“АЯЛЛЫН ХӨТӨЛБӨР”** - 6 дахь жилдээ
- Суралцагчдад өөрийгөө танин мэдэх, мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн **“НАМАЙГ СОНГОХ ШАЛТГААН”** тайлант- хэлэлцүүлэг- 8 дахь жилдээ

БАГШИЙН ХӨГЖИЛ

- Багш, суралцагчдын англи хэлний хэрэглээний чадварыг хөгжүүлэх **“ЦАХИМ НОМ”** унших арга зүйн хөтөлбөр - 2 дахь жилдээ
- Сургалт хүмүүжлийн тулгамдсан асуудлыг хамтран шийдвэрлэх, Х, Y, Z үеийн багш нар бие биенээсээ суралцаж хамтран ажиллах **“БАГИЙН АЖИЛ – БИДНИЙ АМЖИЛТ”** үйл ажиллагаа - 2 дахь жилдээ
- Бүсийн сургуулийн хамтын түншлэлийг бэхжүүлж, харилцан туршлага солилцох **“БАГШ СУРАГЧДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА”** хичээл, сургалт 2 дахь жилдээ
- Эвсэг, бүтээлч хамт олныг төлөвшүүлэн, чөлөөт цагийг зөв өнгөрөөн, монгол орноо танин мэдэх **“АХЛАХ СУРГУУЛИЙН БАГШ НАР”** аяллын хөтөлбөрийг 3 дахь жилдээ хэрэгжүүлэн ажиллаж байна

ЭЦЭГ ЭХИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Суралцагч нэг бүрийн сонирхол хэрэгцээ, төлөвшилд анхаарч, хамтран ажиллах чиглэлээ тодорхойлдог **“ЭЦЭГ ЭХ – СУРАЛЦАГЧ – СУРГУУЛЬ БАГШ”** гуравласан уулзалт- ярилцлага - 5 дахь жилдээ
- Сургуулийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх **“ӨРТӨӨТ ӨДӨРЛӨГ”** 3 дахь жилдээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Суралцагчдын анхаарлын тогтворжилт, мэдээллийг тогтоох, унших хурд, чадварыг нэмэгдүүлэх өглөө бүрийн 30 минутын **“ӨГЛӨӨНИЙ УНШЛАГА”**, сар бүрийн **“НОМ ЗАМ”** хэлэлцүүлэг – 6 дахь жилдээ



Суралцагчдад хэл соёлын мэдлэг чадвар эзэмшүүлэх ахисан болон анхан түвшний **АНГЛИ, ХЯТАД, СОЛОНГОС** хэлний сургалт -7 дахь жилдээ



ЭЦЭГ ЭХ-БАГШ- СУРАЛЦАГЧ гуравласан уулзалт- 5 дахь жилдээ



- ✓ 2023-2024 оны хичээлийн жилд бид X-reading цахим англи ном унших үйл ажиллгааг багш, сурагчдыг оролцуулан тооцоо судалгаатай, хяналт үнэлгээтэй тогтмол, үр дүнтэй зохион байгуулсан.
- ✓ “Ном зам” үйл ажиллгааг англи хэл дээр багш, сурагчдыг 100 хувь оролцуулан амжилттай зохион байгуулсан.
- ✓ МУИС-иас байгалийн ухааны чиглэлээр 5 доктор эрдэмтэн багшийг урьж авчран аймгийн математик, физик, хими, биологи, газарзүйн хичээлийн 146 багшийг чадавхжуулах арга зүйн сургалтыг БШУГ-ийн мэргэжилтнүүдийн хамтаар үр дүнтэй, амжилттай зохион байгуулсан.
- ✓ Математикийн хичээлээр ЭЕШ өгөх аймгийн 500 гаруй сурагчдаас 100 хүүхдийг оролцуулсан МУИС-ийн нэрэмжит "ЭЕШ-2024" сорилго шалгалтыг анх удаа амжилттай зохион байгуулсан.

- ❖ Байгалийн Ухааны хичээлийн багшийн хангалтад анхаарах
- ❖ Сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжтэй байдалд илүү анхаарах
- ❖ Ахлах сургуулийг биеэ даасан байртай болоход анхаарах



МУИС-ийн харьяа Дорнод аймаг дахь ерөнхий боловсролын ахлах сургууль

1.4М хүнд таалагдлаа • 1.6М дагагчид

Мессеж


Таалагджээ

Хайх



Thanks you






ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ДОРНОД АХЛАХ СУРГУУЛИЙН "ҮЛ МАРТАГДАХ ТҮҮХИЙН ЖИМ" АЯЛАЛ

Сурагчдын танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, "Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж эх нутгийнхаа байгалийн үзэсгэлэнт, түүхэн дурсгалт газруудтай танилцан, эх оронч, хамтач үзлийг төлөвшүүлэх, сурагч насны дүрсэмж бүтээх, сургууль хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор Дорнод ахлах сургуулийн 10-12 дугаар ангийн 80 сурагч 8 багш **Халхгол сум- Ялалт музей- Ялалтын хөшөө- Халхгол сумын ерөнхий боловсролын сургууль- Ханан хөшөө- Яковлевын хөшөө- Их бурхант- Ялалт баг- Буир нуур** гэсэн маршрутаар нийт 700 гаруй км замыг туулан 2 шөнө 3 өдрийн аялалыг дүрсэмждүүрэн өнгөрүүлээ.

Why Use 3D?


2D Slides



Slides are a static portrait.

Audience is passive and cannot interact.

3D Models



3D helps foster conceptual understanding and visual and spatial thinking.

Animated 3D models display objects within space in ways text and images cannot.
